



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг зөрчиж зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчиж хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэсэн, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2 дахь заалтыг зөрчиж үргүй зардал гаргасан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, 8.5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.4 дахь хэсэгт заасныг тус тус зөрчин худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зэрэг нийт 4,310.1 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэнд дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:
 - 2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;
 - 2.2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх;
 - 2.3. Зөрчил, дутагдал гаргасан ажилтан, түүнд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох;
 - 2.4. Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчмыг мөрдөж ажиллах;
 - 2.5. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөн ажиллах;

0000475 NRX

2.6. Байгууллагын хөрөнгийг зөв зохистой удирдах, хугацаа хэтэрсэн авлага, өр төлбөрийг бууруулах чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, найдваргүй авлагыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар авах арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

өрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
259. дугаар тогтоолын хавсралт

Иргэний нисэхийн ерөнхий газрын
санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга		Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Бүрдэл дутуу баримт аар хийсэн гүйлгээ	Тушаал, шийдвэр, гэрээ дүгнэсэн актгүй зарцуулсан хөрөнгө	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	24,621.95	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
		Үндсэн баримтгүй зарцуулсан хөрөнгө		20,000.00	
		Дүн		44,621.95	
2	Захиалгын хуудасгүй бэлтгэсэн бараа материал, сэлбэг, хэрэгсэл		Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	12,264.20	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах
3	Үргүй зардал	Хууль бусаар ажлаас халагдсан нь шүүхээр тогтоогдсон хумүүсийн цалин хэлс, нийгмийн даатгалын шимтгэлд	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	69,440.26	"Төсвийн тухай хууль"-ийг мөрдөж ажиллах
		Мөрдөж буй жишгээс их хэмжээгээр илүү олгосон жуух, баярын бичиг дагалдах мөнгөн шагнал		31,920.00	
	Дүн			192,604.46	
4	Хөөн хэлэлцэх хугацаа дууссан барьцаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэлгүй, өглөгийг нэмэгдүүлсэн		Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Дотоод аудитын алба	6,294.10	Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах
5	Зөвшөөрөлгүй бэлтгэсэн хөрөнгө		Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	290,659.60	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
6	Хууль зөрчин бусад байгууллагад хандив, туслёмж болгож өгсөн хөрөнгө ШУТИС, ЗТХЯам		Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	26,800.00	Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
7	"Улсын төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд заавал Төрийн өмчийн хорооны төлөөллийг оролцуулж байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй		Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	612,700.00	Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын заалтыг мөрдөж ажиллах
8	Хөшгийн хөндийд баригдаж буй ОУШНБ-тай холбоотой дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй, цаашид ашиглагдах нь тодорхойгүй зураг, төсөв, судалгааны ажлууд.		Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	790,375.07	Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах
9	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21.3 дахь хэсгийг зөрчсөн.		Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	1,822,452.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах

10	Тендерт оролцогчдын ерөнхий нөхцөлийг магадлалгүй, татварын өртэй, тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй, тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй хуулийн этгээдийг шалгаруулж гэрээ байгуулсан	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	318,390.00	
11	Худалдан авах ажиллагаанд нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно гэсний зөрчиж шууд худалдан авалт хийсэн.	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	148,478.00	
12	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг зөрчиж, Олон улсын нисэх буудлын үүлний эндөр хэмжигч, алсын барааны хараа хэмжигч төхөөрөмжийн үнийг санхүүжүүлэлгүй удаашруулж ААН-ийг хохироосон.	Дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын газар	135,700.00	Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах
Дүн			4,310,164.49	